МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 15 өдөр Дугаар 258 Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжааны орчны орон тооны бус бодлогын зөвлөл байгуулах тухай

Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм"-ийн 3.2, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн зах зээлийн хөгжил, бодлого, зохицуулалтын болон бусад шаардлагатай асуудлуудыг хэлэлцэх, шаардлагатай асуудлаар санал, зөвлөмж боловсруулах үндсэн чиг үүрэг бүхий "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжааны орчны орон тооны бус бодлогын зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Бодлогын зөвлөлийн дарга:

Б.Даажамба	Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн бөгөөд дэд дарга

Бодлогын зөвлөлийн гишүүд:

Т.Жамбаажамц	Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Долгорсүрэн	Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын Хөрөнгийн зах зээлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлтсийн дарга
Ц.Баярмаа	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Л.Нямдагва	Хөдөө аж ахуйн биржийн Зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга
Д.Болормаа	Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлагын газрын дарга
Ж.Эрдэнэбат	"Хөдөө аж ахуйн бирж" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал
З.Эрдэнэхуяг	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбооны удирдах зөвлөлийн дарга

П.Баянсан	МУИС-ийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн хөтөлбөрийн зохицуулагч
Ц.Батсүх	СЭЗДС-ийн Эдийн засгийн онолын тэнхмийн эрхлэгч, доктор, профессор
С.Бадарч	ХААИС-ийн Эдийн засаг бизнесийн сургуулийн Маркетингийн тэнхмийн эрхлэгч, доктор, дэд профессор

Нарийн бичиг:

М.Баярмаа	Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын Хөрөнгийн зах зээлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлтсийн хянан шалгагч

2. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжааны орчны орон тооны бус бодлогын зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг тус зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг бодлогын зөвлөлийн дарга /Б.Даажамба/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай асуудлыг тухай бүр Хорооны хуралд танилцуулж ажиллахыг бодлогын зөвлөлийн дарга /Б.Даажамба/-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН